



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/44

Бор-Өндөр

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,  
техникийн хяналтын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны А/144 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, урьдчилсан үзлэг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичиг:

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд:

Татварын Улсын ахлах байцаагч

Татварын Улсын байцаагч

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Замын цагдаагийн зохицуулагч

3. Сумын хэмжээнд 3 буюу түүнээс дээш жил үзлэг оношилгоо болон татварт хамрагдаагүй тээврийн хэрэгслийн татварын өрийг гаргаж, тухайн татвар төлөгчтэй холбогдож өрийг төлүүлэх ажлыг багийн Засаг дарга нарт даалгасугай.


4. Төсөвт байгууллагын авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг тооцоолол болон нэхэмжлэлийн жагсаалтаар тулгаж, өрийг бүрэн төлүүлж дуусахыг татварын албанд даалгасугай.

5. Авто тээврийн үндэсний төв дээр хасагдахаар хүлээгдэж байгаа төлөвтэй тээврийн хэрэгслийн татварын өрийг барагдуулж, хасагдах материалын бүрдлийг татвар төлөгчөөр бүрдүүлэн, авто тээврийн газарт хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

6. Авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт ороогүй, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчид татвар, төлбөр торгуулиа төлөх санамж, анхааруулга өгөхийг ажлын хэсэгт даалгасугай.

7. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын урьдчилсан үзлэгт хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ